



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/207

Улаанбаатар хот

**Мал, амьтны гоц халдварт шүлхий  
өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын  
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/251 дүгээр тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1227 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Багахангай дүүргийн нутаг дэвсгэр дэх шүлхий өвчинд мэдрэмтгий мал, амьтны вакцины дархлааны хугацаа дуусч байгаа тул ээлжит дархлаажуулалтын ажлыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор шуурхай зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх)-т үүрэг болгосугай.

2.Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад тус дүүргийн өвчинд мэдрэмтгий нийт 2800 толгой мал, амьтныг вакцинжуулалтанд бүрэн хамруулж ажиллахыг Мал эмнэлэг үйлчилгээний нэгж "ЦЭФ" трейд (А.Цэрэндагва)-д, хороодын Засаг дарга (Нямзав, Б.Батзориг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах зүү тариур, халдвар хамгаалал, хөдөлмөр хамгаалал, шатах тослох материал, ажиллах хүн хүчний зардлыг хавсралтаар баталсугай.

4.Гоц халдварт өвчний дархлаажуулалтад шаардагдах 1.972.200 (Нэг сая есөн зуун далан хоёр мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн болон нэгдсэн удирдлагаар ханган, санхүүгийн тайланг үйл ажиллагаа зохион байгуулж дууссанаас хойш ажлын 5 хоногийн дотор ирүүлэхийг Мал эмнэлгийн тасаг (Я.Батсүх)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 10 сарын 11 ны өдрийн 4657 дугаар  
захирамжийн хавсралт



МАЛ АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТ БОЛОН ХЯНАЛТЫН АЖИЛД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТӨСӨВ

1.Шатахуун, зүү тариур, халдвар хамгаалал, холбоо, зарлан мэдээллийн зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт
1	Шатахуун А-92	л	180	2410	433,800.00
2	Тариур	ш	500	400	200,000.00
3	Зүү	ш	600	700	420,000.00
4	Нэг удаагийн маск	ш	100	200	20,000.00
5	Нэг удаагийн малгай	ш	100	200	20,000.00
6	Нэг удаагийн бээлий	Хайрцаг	2	35000	70,000.00
7	Цэнхэр спирт	л	2	6000	12,000.00
8	Шатахуун А-92 /вакцины татан авалт болон вакцинжуулалтын ажлын гүйцэтгэлийн үеийн хяналт шалгалтад/	л	40	2410	96,400.00
ДҮН					1,272,200.00

2.Ажиллах хүчний зардал

№	Ажиллах хүч	Тоо	Нэг өдрийн цалин	Нэг өдрийн нийт цалин	Ажиллах хоног	Нийт ажлын хөлс
1	Туслах ажилтан	2	50000	100000	7	700,000.00
ДҮН						700,000.00
Нийт дүн						1,972,200